



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/376

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаан хуулбар овгийн Төмөрийн Бямбасүрэн (ФБ66041654)-ийн ирүүлсэн хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/422 дугаар захирамжийн хавсралтын 9 дэх хэсэгт Төмөрийн Бямбасүрэн (ФБ66041654)-д эзэмшүүлсэн Мөрөн сумын 7 дугаар баг 29-13в тоотод байршилтай 6712011794 нэгж талбарын дугаар бүхий гэр, орон сууцны хашааны газрын зориулалттай 293м<sup>2</sup> газрыг иргэн Мижиддорж овгийн Алтанхуягийн Золбоо (ХИ85081701)-д үлдсэн 8 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/422 дугаар захирамжийн хавсралтын 9 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч иргэн Мижиддорж овгийн Алтанхуягийн Золбоо (ХИ85081701)-той газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

6712011123